

ХАН-УУЛ ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАЙГУУЛЛАГЫН НУУЦЫН ГЭРЭЭ

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэхүү гэрээг нэг талаас Хан-Уул Эрүүл мэндийн төвийн захиргааг төлөөлж Э.Бодьцэцэг/цаашид ажил олгогч гэх/, нөгөө талаас иргэн овогтой нар “Байгууллагын нууцын тухай хууль”- ийг үндэслэн дор дурьдсан нөхцлүүдийг харилцантохиролцож байгуулав.

1.2.Энэхүү гэрээ нь Монгол Улсад мөрдөгдөж буй хуулиудын нууцын холбогдолтой заалт, удирдах дээд байгууллагаас гаргасан журам дүрмийг үндэслэнэ.

1.3.Энэхүү гэрээгээр байгууллагын нууцыг тогтоох, хамгаалах зорилгоор холбогдох мэдээ, баримт бичгийн /компьютер дэх файл, фолдер, нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, ша ардлагатай техник, тоног төхөөрөмж /, нэр төрөл чанар байдал, зэргийг харгалзан хүлээлгэн өгч, хүлээн авсан актыг харгалзан хохирол учруулсан тохиолдолд хариуцлага хүлээлгэхэд энэ гэрээний зорилго оршино.

ХОЁР. АЖИЛ ОЛГОГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

2.1.Нууц хариуцагчийг ажиллах нөхцөл, орон байр, төхөөрөмж, хэмжих шалгах хэрэгсэл, хөтлөгдөх бүртгэлийн маягт, заавраар бүрэн хангана.

2.2.Нууц хариуцагчийгажлаас халагдах, өөрчлөгдөхөд байгууллагын захригаанаас томилогдсон комсс нууц хариуцагчийн нууцад хамаарагдах зүйлийн тооцоог бүрэн хийж дүгнэлт гаргана

2.3.Нууц хариуцагч гэрээг зөрчиж хариуцсан нууцад хамаарагдах зүйлийг алдагдуулах, будиалтуулах, устгах, үрэгдүүлсэн явдал илэрвэл хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

2.4.Нууцад хамаарагдах зүйлийг санаатайгаар өөр зүйлд ашигласан устгасан үрэгдүүлж шамшигдуулсан хүнийгүйдсэн гэмт хэргийн шинж чанараас шалтгаалан ажлаас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.

ГУРАВ. НУУЦ ХАРИУЦАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.1.Нууц хариуцагч нь “Байгууллагын нууцын тухай хууль”, Монгол улсад мөрдөгдөж буй хуулиудын нууцын холбогдолтой заалт, удирдах дээд байгууллагаас гаргасан журам, дүрэм болон байгууллагын дотоод журамд захирагдаж өөрийн гүйцэтгэх ажил үүрэг, сар, улирал, жилийн төлөвлөгөөт ажлыг цаг хугацаанд нь биелүүлж ажиллана.

3.2.Өөрийн хариуцаж байгаа нууцад хамаарагдах зүйлийг хүлээн авахдаа түүний тоо, чанар, бүрэн бүтэн эсэх болон зохих баримт бичгүүдтэй тохирч байгаа эсэхийг шалгаж дутуу зүйлийг нөхөж авна.

3.3.Хариуцаж байгаа нууцад хамаарагдах зүйл нь компьютерийн хадгалалтын нөхцлөөс болж чанар алдагдах устаж үрэгдэхэд хүрвэл тухай бүр нь байгууллагын удирдлагад мэдэгдэж арга хэмжээ авхуулж байна.

3.4.Хариуцаж байгаа нууцад хамаарагдах зүйлийг тасгийн эрхлэгч болдон бага эмчид мэдээ тайланг тухай бүр нь гаргаж өгч, тооцоо хийхэд биеэр оролцож байх ба тооцоо хийгдэж байгаа нууцад хамаарагдах зүйл нэг бүрийг биечлэн үзүүлж тооцуулна.

3.5.Нууцад хамаарагдах зүйлийг хадгалалт хамгаалалт, хэрэглээний талаар зайлшгүй шаардагдах, тоног төхөөрөмж, ажлын багаж хэрэгсэл, цоож, лац, ломбо бүртгэлийн маягт заавар зэргээр хангаж өгөхийг шаардах эрхтэй.

ДӨРӨВ. БУСАД ЗҮЙЛ

4.1.Гэрээтэй холбогдон гарсан асуудлыг хоёр тал харилцан тохиролцож шийдвэрлэх ба тохиролцоогүй асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.2.Энэхүү гэрээг 20.... оны дугаар сарын –ны өдөр байгуулав.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Хан-Уул Эрүүл мэндийн төвийн
даргаЭ.Бодьцэцэг

Нууц хариуцагч ажилтан
.....